

Монгол хэлний бүтээврийн утгазүйн ангилал

Д.Бадамдорж (МУИС)

Бүтээвэр бол хэлний цуваа бүтцийн дотор утга илтгэгч хамгийн бага нэгж байхын хамт, хам бүтцийн дунд үгийн сан-хэлзүйн айг бүрдүүлэх махбод болно.

XX зууны хэл шинжлэлд хэлний нөхөх, үл нөхөх байрлалын зарчмыг үндэслэж, нэг бүтээврийн 2-4 хувилбар уу, эсвэл хоёр бүтээвэр үү гэдгийг (1: 193-204) ялган тогтоож бүтээврийг хэлбэр, байрлал, хувилбар, утга талаас нь нэлээд шинжилсэн билээ.

Мөн бүтээвэр нь 1. Давтагдах, 2. Утгат, 3. Үл хуваагдах, 4. Хийсвэрлэх гол шинжтэй (2:273-276) болохыг тодорхойлсон байна.

Эдгээр шинжийн дотроос утгат шинж нь бүтээврийн гүн бүтцийн ойролцоо утга, эсрэг утга, төсөө утга, төрөл утга, ижил хэлбэрийн утга тэргүүтнээр хэмжигдэх юм. Ийм ангилал хийхэд бүтээврийн утгын талаархи урьд өмнө хийсэн судалгаа чухал болно.

-Эрдэмтэн Дэлгэрмаа (БНХАУ) "Орчин цагийн монгол хэлний бүтээврийн утгыг үгсийн сангийн утга, хэлзүйн утга ба нэмэлт утга гэж ерөнхийд нь гурван зүйлээр хураангуйлж болно". (3:112) хэмээн бүтээврийн утгыг ангилсан байна.

-Эрдэмтэн Ц.Өнөрбаян "...Язгуурын утга нь цөм, дагаврын утга нь цөмийн бүрхүүл мэт ажээ... Нөхцөл нь хэлзүйн ба хэлзүй-үгийн сангийн утгатай". (4:87-92) хэмээн утгын ажиглалт хийсэн явдал бүтээврийн утгыг шинжлэхэд ач тустай байна.

-Эрдэмтэн М.Базаррагчаа монгол хэлний бүтээврийн бүтцийг ажиглаж, дараахи ангилал хийжээ. Үүнд:

1. Ойролцоо бүтээвэр - дал, - ц

- *dal*, - *ca*

явдал ~ *явц*, суудал ~ *сууц*;

2. Төсөөт бүтээвэр - рхаг, - рхуу

- *rqaγ*, - *rqau*

уулархаг ~ *уулархуу*, усархаг ~ *усархуу*;

3. **Эсрэг бүтээвэр** -тай, -гүй

- tai, - gūi

тухтай – тухгүй, малгайтай – малгайгүй,

4. **Зүйлчилсэн бүтээвэр** хүн амьтны үндсэн онцлогийг

илтгэсэн – тан, - чин, - ч, - аач, - ган, - мад дагавар:

араатан, усчин, ахмад, бэргэн, самган, зураач... (5:58-59) гэжээ.

Энэхүү бүтээврийн утгын ангилал бол бүтээврийг үгийн сангийн үг нь утга илэрхийлж байдгийн нэгэн адилаар авч үзсэн, урьд өмнө төдий л их яригдаагүй шинэлиг зүйл болно.

Академич Ш.Лувсанвандан “Үгийн цөм болох язгуур нь уул үгийн хамгийн ерөнхий утгыг заах дохио байдаг бол үгийн цөмийн бүрхүүл болох дагавар нь язгуур бүтээвэртэйгээ нөхцөлдөн гарч болох янз бүрийн чанар, хөдөлгөөний дохио болно”. (6:103) хэмээн бүтээврийн утгын нөхцөлдөх шинжийг хэлжээ. Энэ мэт монгол хэлний бүтээврийн утгын талаархи эрдэмтдийн санал, дүгнэлт зэргийг анхааралдаа авч, бүтээврийн утгын ангилалын талаар өгүүлье.

Монгол хэлний бүтээврийн гүн бүтцийг үгийн сангийн үг, утгазүйн үг(8:14-18)-ийн нэг адилаар авч үзэж, дараахи ангиллыг хийж болох юм. Энэ ангилал нь хэлний цуваа бүтцийн доторхи бүтээврийн утгын зүйлчлэл болно. Үүнд:

1. **Ойролцоо утгат бүтээвэр**

Нэг бүтээврийн утга нөгөө бүтээврийн утгатай ойролцоо байх нь язгуур, дагавар, нөхцөл бүтээврийн алинд ч хамаатай байна.

Язгуур бүтээвэр бол ерөнхий утгаараа ойролцоо нь мэдэгдэнэ. Жишээлбэл:

ца – (цагаан өнгийн ерөнхий утга)

цас, цан, цаас, цаваг, цавь, цавьдар, цагаа, цагаагч, цагаан, цал, цахиур, цахи -, цааз гэх мэт үгэнд тохиолдоно.

хя – (цагаан, цагаавтар ерөнхий утга)

хяруу, хярам, хяраа, хялай-, хялман, хиурс, хярмаг гэх мэт үгэнд тохиолдоно. Ца-, хя- язгуур ойролцоо утгатай гэж болно.

Дагавар бүтээвэр бол үгийн сангийн утгаараа ойролцоо байдаг. Жишээ нь:

оёдол (оёх үйлийн үр дүнгийн нэр)

оёо (оёсон газар нь)

оёос (оёсон байдлын нэр) гэхэд энд –дол, - оо, -оос гэсэн гурван дагавар бүтээвэр ойролцоо утгатай байна.

Нөхцөл бүтээвэр бол үг хоорондын ижил харьцаа заах байрлалд ойролцоо утгатай болно. Жишээлбэл:

Бат гармагц

гарангуут

гарсаар түүнтэй тааралдав.

Үйлийн тийн ялгалын –магц, -нгуут(-гуут), -саар нөхцөлүүд гарах үйл удаан үргэлжлээгүй утга-харьцаагаар ойролцоо байна.

Мөн өгүүлбэрийн нөхцөлийн дотор ч гэсэн ойролцоо утгат бүтээвэр бий. Жишээ нь:
 -Та сайн байна уу?
 -Таны алдар хэн бэ?
 -Та хэлж өгнө үү?
 -Та хаана суудаг вэ? гэсний *-уу(үү)-бэ(-вэ)* нөхцөлүүдэд асуух ойролцоо утга байна.

2. Эсрэг утгат бүтээвэр

Нэг бүтээврийн утга, нөгөө бүтээврийн утгатай эсрэг(утгатай) байх нь язгуур, дагавар, нөхцөл бүтээврийн аль алинд хамаатай байна.

Язгуур бүтээвэр-ийн ерөнхий утга эсрэгцэнэ. Жишээ нь:

дэ-	дээр	дээш	дээж	дээдэс	дээгүүр
до-	доор	доош	доож	доодос	доогуур
э-	энэ	энд	эд	(ойр)	
тэ-	тэр	тэнд	тэд	(хол)	

гэх мэт.

• **Дагавар бүтээвэр** эсрэг утгат байх нь түгээмэл байна. Жишээ нь:
гуна- гунж, дөнө- дөнж, олигтой- олиггүй гэх мэт.

• **Нөхцөл бүтээвэр** эсрэг утга илтгэхдээ цуваа бүтэц буюу өгүүлбэрийн нийлц үүссэн үед утга тодорхой болно. Жишээлбэл:
Доржийг харсаар танилаа. Доржийг харсаар сууна гэхэд – саар нөхцөл түргэн-удаан гэх хэрэглээний эсрэг утга хадгалж байна. Мөн Дорж гэрээсээ явлаа. Дорж гэр лүүгээ явлаа. гэхэд –ээс, - лүү хоёр нөхцөл эсрэгцсэн харьцаа-утга зааж байна.

3. Төсөө утгат бүтээвэр

• **Язгуур бүтээвэр** а, э болон бусад эгшгийн сэлгээгээр бүтсэн бол төсөө утгатай байна. Жишээлбэл:
цагаа гэхийн ца - язгуур хэлбэр, утгаараа төсөөтэй юм.
цэгээ цэ -

Энэчилэн, га- омгийн язгуураар бүтсэн *гадгар, гэдгэр, годгор, гудгар, гөдгөр гүдгэр* гэх үгсийн *га-, гэ-, го-, гу-, гө-, гү-* язгуур төсөө утгатай болно.(7:63) Төсөө утгат үг үүсгэнэ.

• **Дагавар бүтээвэр** дуудлага, утгаараа төсөөтэй байна. Жишээлбэл: *Махсаг-Махсуу, (8:137)*
уулархаг-уулархуу, ихэрхэг-ихэрхүү, өсгийд-өсгийлд-, гоёмсог-гоёрхог гэх мэт.

• **Нөхцөл бүтээвэр** нь төстэй хэлэгдэх нь цөөн юм. Гэвч явангаа- явангуут, бичингээ-, бичингүүт гэх мэтэс нь төсөө утгат бүтээвэр болно.

4. Төрөл буюу зүйлчилсэн утгат бүтээвэр

Монгол үгийн язгуурын ерөнхий утга нэгэн орон үүсгэх төрөл утгатай байж болно. Жишээ нь:

Өнгө зүсэм_ заасан төрөл буюу зүйлчилсэн утга бүхий язгуур бүтээвэр:

а -: айраг, ааруул, аарц, аг, азай, алаг, алт, ариг... үгийн ерөнхий утга,

ө -: өөх, өр(үүр), өглөө, өл(халзан), өгөр, өгөр-, өнгөр, өгөрш-, өнгө, өгий-, өехий гэх мэт үгсийн ерөнхий утга,

но -: ногоо, ногоон, номин, ногоолин гэх зэрэг үгийн ерөнхий утга,

бо -: бор, борог, борогч, борлог, боз, борзон, борц, боргошуу, борло-, гэх мэт үгийн ерөнхий утга,

бу -: будан, буд-, будаг, буурал, буурагч, булган, бууралт-, гэх мэт үгийн ерөнхий утга,

ха -: Хар, харанхуй, халтар, халзан, халиун, харагч, халиуч, халтагч, харлаг, харуй гэх мэт үгийн ерөнхий утга,

хя -: Хяруу, хярам, хяраа, хялай-, хялман, хиурс(хуурс), хярмаг гэх мэт үгийн ерөнхий утга,

хо -: Хондон, хонгор, хонхир, хоормог, хохимой, хохидог гэх мэт үгийн ерөнхий утга,

ху -: Хундан, хун, хуехай, хул, хунгар, хужир, хуйх, хуехайр, хунгарла-, хужирла- гэх мэт үгийн ерөнхий утга,

хө -: Хөө, хөх, хөхөгч, хөвхөр, хөргээр, хөхөө(өөёл) хөхөмдөг, хөхөр-, хөгц гэх мэт үгийн ерөнхий утга,

ца -: Цас, цан, цаас, цаваг, цавь, цавьдар, цагаа, цагаагч, цагаан, цал, цахиур, цахи-, цааз гэх мэт үгийн ерөнхий утга,

цэ -: Цэгээ, цэгээн, цэхэр, цээл, цэнхэр, цэр, цэцгий, цэцэг, цэлмэг, цэвдэг, цэвэр, цэмцгэр, цээр гэх мэт үгийн ерөнхий утга,

цу -, **ча** -: Цус, чалбан, царай, час улаан, чармай гэх мэт үгийн ерөнхий утга,

ша -: Шар, шарга, шороо, шавар, шарагч, шаваг гэх мэт үгийн ерөнхий утга. Эдгээр язгуур өнгө зүсэм заахаараа төрөл болно..

• **Дагавар бүтээвэр** утгаараа төрөл байх нь түгээмэл байна.

Жишээ нь:

Хүнийг илтгэгч утгатай дараахи дагаврууд төрөл утгат бүтээвэр болно.

- **чин** : Ажилчин, малчин, хоньчин;
- **гч** : Сурагч, ачигч, нягтлан бодогч;
- **ч** : Тогооч, эмч, жолооч;
- **тан**⁴ Оюутан, сэхээтэн, мэргэжилтэн;
- **гтай**² Хатагтай, эрэгтэй, эмэгтэй;
- **гай**² Авгай, гэргий, худгуй;
- **уул**² Тагнуул, харуул, хэвтүүл;
- **ц** : Хоноц, зарц, харц;
- **аач**⁴ Зураач, бичээч, манаач;
- **ган**⁴ Самган, бэргэн, өвгөн;
- **ч** : ач, жич, гуч, дөч, тач,
- **га**² дарга(дар+га),

- л : захирал(захира+л),
- д : Сайд, ард, хүүхэд гэх мэт.

• **Нөхцөл бүтээвэр** айн утгаараа төрөл утгат болно. Жишээ нь:
-минь, **-маань** : Ганц олон тоо ялгаж, нэгдүгээр биеийг заана.

Ах минь, ах маань;

-чинь, **тань**: Ганц олон тоо ялгаж, хоёрдугаар биеийг заана.

Ах чинь, ах тань;

-нь (ану, энү): Гуравдугаар биеийг илтгэж хэрэглэгдэнэ.

Ах нь гэх мэт.

Эдгээр нь биед хамаатуулах айн утгаар төрөл болно.

5. Ижил бүтээвэр

Бүтээврийн хэлбэр, утгын шинжлэлээр ижил бүтээвэр хэмээх ойлголт хэл шинжлэлд бий болсон байна. Ижил бүтээврийн гүн бүтэц утгасудлалд ихээхэн сонирхол татдаг билээ.

Эрдэмтэн Г.Жамбалсүрэн "Хамтрахын тийн ялгалын –тай₁, дагаврыг үйл үгийн хэлбэр бүтээх –тай₂, үг бүтээх –тай₃ дагавраас ялган салгах хэрэгтэй. Жишээлбэл:

а). *аавтай* (үгийн хэлбэр)

б). *яв-ууш-тай* (үйл үгийн дагавар)

в). *хайртай* (үг бүтээх дагавар)

гэдгийн –тай₁, –тай₂ (хэлзүйн ижил хэлбэр grammatical homonyms)–тай₃ нь үг бүтээх морфем болно гэж үзэж байна.(9:15) гэж ижил бүтээврийн асуудлыг хөндсөн билээ.

• **Язгуур бүтээвэр** ерөнхий утгаараа ондоо, хэлбэр ижил байх тохиолдол үлэмж арвин байна. Жишээ нь:

а - *авир, ааш, ааль, ааг, ая, аяг, ад, атхаг, адайр, адгуу, ардаг, ан зан, агад-, адга-* гэх мэт үгийн язгуур бүтээвэр нь зан аашийн утгатай байхад,

а - *аварга, уужим(агужим), уудам(агудам), уул(агула), агуй, асар, алс, арвин, аугаа* гэх мэт үгийн язгуур бүтээвэр нь уудам талбиу хэмээх утгатай байна. Энэ хоёр **а**- язгуур бүтээвэр хэлбэр адил, утга өөр ижил бүтээвэр болно.

• **Дагавар бүтээвэрүүд** өөр хоорондоо, авиазүйн түүхэн хөгжил, хувьслын шалтгаанаар ижил бүтээвэр болсон байдаг. Орчин цагийн монгол хэлэнд ийм бүтээвэр олширч байна. Жишээлбэл:

Монгол хэлний *орхиц, гарц, явц, орц, барьц, хаац, бууц, сууц, ирц, хольц, сорьц, түлхэц, хийц* гэх мэтээр үйл үгээс нэр үг бүтээх дагавар **-ц** бүтээвэр бол, *дулаац-, бүлээц-, давхац-, эвц-, зэрэгц-, мөрийц-, барьц-, тэнц-, тооц-, зугаац-, булхайц-, дургүйц-, аягүйц-* гэх мэтээр нэр үгээс үйл үг бүтээх **-ц** бүтээвэртэй ижил бүтээвэр болно.

Эл хоёр бүтээврийн нэг нь бодот юмыг нэрлэсэн нөгөө нь үйлийг нэрлэсэн байгаагаар ялгаатай буюу өмнөө утгатай, ижил хэлбэртэй тул ижил бүтээвэр юм. Нэг бүтээвэр биш.

• **Нөхцөл бүтээвэр** ижил хэлбэртэй байх нь цуваа бүтцийн гинжин байдлаас тодорхой мэдэгдэнэ. Жишээ нь:

Шингэн бодис шингэн оржээ. Нохойн дуу ойртон, гэрээс аргалын утаа суунаглана. Энэ жишээнд *шингэн, шингэн, нохойн, ойртон* гэх зэрэгт буй –н бүтээврүүд ижил хэлбэртэй байна.

Манай хэлний "бүлээн" хэмээх тэмдэг нэрэнд –дэ, –рэ, –сэ, –цэ дагавар залгаж, үйл үг бүтээхэд дараахи зохистой зохисгүй олон утга илэрч болно.

1. Бүлээдэ- :

- а).Цай бүлээдэх, ер шингэн зүйл бага зэрэг халах (Зохистой)
- б).Шингэн зүйл хэтэрхий бүлээн болох (Зохисгүй)

2. Бүлээрэ-:

- а).Дулаарах, цаг агаар сэрүүнээс бүлээн дулаан болох (Зохистой),
- б).Хүүхэд, настан нар өвчний улмаас халуурах (Зохисгүй).

3. Бүлээсэ-:

- а).Нэлээд бүлээн болж, аятай байх хөл гар бүлээсэж байна. (Зохистой).
- б).Бага зэрэг бүлээн болох. Түлш муу тул цай дөнгөж бүлээсэж байна.(Зохисгүй).

4. Бүлээцэ-:

Бага зэрэг дулаацах. Хөл бүлээцэх, Сэтгэл бүлээцэх ч гэнэ. (Зохистой) (10:116-117).

Дээрх дөрвөн үйл үгийн хэрэглээ, утга тэргүүтнээс үзвэл –дэ, –рэ, –сэ, –цэ зэрэг бүтээврийн утгазүйн ялгаа ажиглагдаж байгаа юм.

Ном зүй

1. Ш. Лувсанвандан. "Монгол хэл шинжлэлийн асуудлууд". УБ.1981. 193-204 дэх тал.
2. *Общее языкознание*. Под общей редакцией А.Е.Супруна. Минск. 1983. стр. 273-276.
3. Дэлгэрмаа."Монгол хэлний утгасудлал". Лиёонингийн үндэсний хэвлэлийн хороо. 2001. 112 дахь тал.
4. Ц. Өнөрбаян."Орчин цагийн монгол хэлний үг зүй". УБ.1998.87-92 дахь тал.
5. *Сорил-2000*. (Монгол хэл-уран зохиол, монгол бичиг).УБ.2000. 58-59 дэх тал.
6. Ш.Лувсанвандан."Орчин цагийн монгол хэлний бүтэц". Дэд дэвтэр. УБ.1999.103 дахь тал."
7. Д.Бадамдорж. "Монгол хэлний утгасудлал",Тэргүүн дэвтэр. УБ.2001.63 дахь тал.
8. Д.Бадамдорж. "Монгол хэлний утгасудлал". Дэд дэвтэр. УБ.2001.14-18, 137 дахь тал.
9. Г.Жамбалсүрэн. "Монгол хэлшинжлэлийн онолын зарим асуудал". УБ.1987.15 дахь тал.
10. Я.Цэвэл."Монгол хэлний товч тайлбар толь". УБ.1966.116-117 дахь тал.